



ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх,

Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх авто замаар гүйцэтгэх зорчигч ба ачаа тээвэрлэлтийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж,

дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл Хамрах хүрээ

1. Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгслээр Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улсын хооронд, эдгээр улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд, гуравдагч улс болон Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын улсын нутаг дэвсгэрийн хооронд, мөн буцах чиглэлийн авто замаар гүйцэтгэх зорчигч ба ачаа тээвэрт хамаарна.

2. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын улсын нутаг дэвсгэрт байрлах хоёр цэгийн хооронд зорчигч ба ачаа тээвэрлэлт гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

2 дугаар зүйл Нэр томьёо

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд:

1. “Тээвэрлэгч” гэж тухайн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж буй Монгол Улс эсхүл Бүгд Найрамдах Польш Улсад оршин суугаа, эсхүл бүртгэлтэй хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, эсхүл хуулийн этгээд биш бүлэг хүмүүсийг хэлнэ.

2. **“Тээврийн хэрэгсэл”** гэж авто замаар зорчигч ба ачаа тээвэрлэхэд зориулагдан бүтээгдсэн моторт тээврийн хэрэгсэл, эсхүл ачаа тээвэрлэхэд зориулагдсан моторт бус чирэх зориулалт бүхий чиргүүлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолтод хагас чиргүүл эсхүл чиргүүлтэй холбогдсон моторт тээврийн хэрэгслээс бүрдэх тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн мөн хамаарна.

3. **“Автобус”** гэж жолоочийг оролцуулан есөөс илүү хүнийг авто замаар тээвэрлэх зориулалттай бүтээгдсэн механикжсан тээврийн хэрэгслийг хэлнэ.

4. **“Зорчигчийн байнгын тээврийн үйлчилгээ”** гэж урьдчилан тогтоож зарласан тариф болон хөдөлгөөний цагийн хуваарийн дагуу тусгайлан тогтоосон замналын дагуу автобусаар зорчигч тээвэрлэх үйлчилгээг хэлнэ.

5. **“Зорчигчийн захиалгат тээврийн үйлчилгээ”** гэж дор дурдсан нөхцөлүүдийг хангасны үндсэн дээр зохион байгуулалттай бүлэг зорчигчдыг эхний цэгээс эцсийн цэг хооронд явах, буцах чиглэлд давтамжтайгаар тээвэрлэхийг хэлнэ. Үүнд:

а) Аяллын эхний цэгээс гарсан бүлэг зорчигч тус бүрийг аяллыг эхлүүлсэн цэгт буцаан тээвэрлэж ирэх;

б) Захиалгат үйлчилгээнд эхний буцах аялал болон сүүлийн гарах аялал нь зорчигчгүй/хоосон хийгдэнэ.

Аяллын эхний болон эцсийн цэг гэж аялал эхлэх болон дуусах цэгийн байршлыг хэлэх бөгөөд аль ч тохиолдолд 50 километрийн радиусын дотор ойр орших газрыг хамарна.

6. **“Зорчигчийн байнгын бус тээврийн үйлчилгээ”** гэж энэ зүйлийн 4 ба 5 дахь хэсэгт зааснаас бусад тээвэрлэлтийг хэлнэ.

7. **“Гуравдагч Улс”** гэж энэхүү хэлэлцээрийн Хэлэлцэн тохиролцогч тал биш аливаа улсыг хэлнэ.

8. **“Эрх бүхий байгууллага”** гэж автотээврийн асуудал хариуцсан Хэлэлцэн тохиролцогч талын Засгийн газрын байгууллага, эсхүл тэдгээрээс эрх олгогдсон төлөөлөгчийг хэлнэ.

Зорчигч тээвэр 3 дугаар зүйл Зорчигчийн байнгын тээвэр

1. Зорчигчийн байнгын тээврийн үйлчилгээг Хэлэлцэн тохиролцогч тал бүрийн тухайн улсын дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

2. Зорчигчийн байнгын тээврийн үйлчилгээний зөвшөөрлийг харилцан тохиролцоонд үндэслэн Хэлэлцэн тохиролцогч талуудын тухайн улсуудын эрх бүхий байгууллагуудаас өөрийн улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх тээвэрлэлтийн үйл ажиллагааны тодорхой хэсэгт олгоно.

3. Зөвшөөрлийн хүсэлтийг тээвэрлэгчийн үүсгэн байгуулагдсан тухайн улсын эрх бүхий байгууллагад гаргана. Эрх бүхий байгууллагаас хүсэлтийг хүлээн зөвшөөрвөл, зөвшөөрлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

4. Энэхүү хэлэлцээрийн 12 дугаар зүйлд заасан Хамтарсан хороо нь зөвшөөрлийн хүсэлтийн маягт болон шаардагдах нэмэлт баримт бичгийн бүрдлийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

5. Зөвшөөрлийг олгох, татгалзах шийдвэрийг онцгой нөхцөл байдал үүсээгүй бол 3 сарын дотор шийдвэрлэнэ.

6. Хэлэлцэн тохиролцогч талуудын тухайн улсын эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийн бичгийг урьдчилан солилцох ба тээвэрлэлтийг зохион байгуулна. Зөвшөөрөлд дараах мэдээллийг багтаасан байна:

- 1) тээвэрлэгчийн нэр;
- 2) тээвэрлэлтийн замнал;
- 3) цагийн хуваарь;
- 4) зорчигч тээвэрлэлтийн үнэ;
- 5) зорчигчийг буулгах, суулгах зогсоол;
- 6) тээвэрлэлтийн хугацаа болон давтамж.

7. Хэлэлцэн тохиролцогч талуудын улсын эрх бүхий байгууллагууд нь зөвшөөрөл олгоход шаардлагатай бусад нэмэлт мэдээллийг авах хүсэлтийг харилцан гаргаж болно.

8. Үйлчилгээний нөхцөлүүдийг өөрчлөх болон үйлчилгээг цуцлах/зогсоох асуудлыг энэхүү зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

9. Гуравдагч улс эсхүл Хэлэлцэн тохиролцогч аливаа талын улсын нутаг дэвсгэрт эвдэрсэн автобусыг солих ба түүгээр тээвэрлэсэн зорчигчдыг авахаар явуулж буй зорчигчгүй автобусанд зөвшөөрлийг шаардахгүй.

4 дүгээр зүйл

Зорчигчийн байнгын бус ба захиалгат тээвэр

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын тухайн улсуудын нутаг дэвсгэрийн хооронд эсхүл тэдгээр улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй зорчигчийн байнгын бус болон захиалгат үйлчилгээ нь Хэлэлцэн тохиролцогч талуудын тухайн улсуудын эрх бүхий байгууллагаас олгогдсон зөвшөөрлийн үндсэн дээр хийгдэнэ.

2. Энэхүү хэлэлцээрийн 12 дугаар зүйлд заасан Хамтарсан хороо нь энэ зүйлд заасан тээвэрлэлтэд тавигдах тээврийн хэрэгслийн техникийн, хүрээлэн буй орчны болон аюулгүй байдлын стандартын шаардлагуудыг тохиролцоно.

5 дугаар зүйл

Ачаа тээвэр

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын тухайн улсуудын нутаг дэвсгэрийн хооронд, эсхүл тэдгээр улсын нутаг дэвсгэрээр дамжин, эсхүл гуравдагч улс руу/аас тээврийн хэрэгсэл, түүний бүрэлдэхүүнээр ачаа тээвэрлэхэд энэхүү хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аяллын төрөл ба энэхүү хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тээвэрлэлтийн төрлөөс бусад

тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авна.

2. Энэхүү хэлэлцээрийн 12 дугаар зүйлд заасан Хамтарсан хороо нь зөвшөөрлийн тоо, ангилал болон ашиглалтын нөхцөлийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3. тээвэрлэлт, тээврийн хэрэгсэл бүрд зөвшөөрлийг олгоно. Зөвшөөрөл нь ирэх, буцах чиглэлийн нэг удаагийн тээвэрлэлтэд хүчинтэй. Ачаагүй тээврийн хэрэгслийн аялалд мөн зөвшөөрлийг шаардана.

4. Хэлэлцэн тохиролцогч талуудын улсуудын эрх бүхий байгууллагууд жил бүр бөглөөгүй зөвшөөрлийн бичгийг тохиролцсон тоогоор солилцоно.

5. Зөвшөөрөл нь хуанлийн нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.

6 дугаар зүйл

Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тээвэрлэлт

1. Дараах төрлийн тээвэрлэлт зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөгдөнө:

- 1) нүүлгэн шилжүүлж буй хөдлөх хөрөнгийн тээвэрлэлт;
- 2) арилжааны зориулалттай бус эсхүл үзэсгэлэн, яармагийн арга хэмжээнд зориулсан урлагийн бүтээл зэрэг материал, дагалдах хэрэгслүүд;
- 3) спортын арга хэмжээнд зориулж ашиглах тээврийн хэрэгсэл, мал амьтан, спортын тоног төхөөрөмж ба дагалдах хэрэгслүүд;
- 4) зөвхөн олон нийтийн сурталчилгаа болон мэдээллийн зорилгоор ашиглах театрын засал чимэглэл, эд зүйлс, хөгжмийн зэмсэг болон дагалдах хэрэгсэл, материал, мөн радио бичлэг, кино, телевизийн бүтээл, циркийн үзүүлбэрт ашиглах зүйлс;
- 5) нас барагчийн чандар, шарил тээвэрлэх;
- 6) хүмүүнлэгийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, мөн яаралтай тусламж эсхүл байгалийн гамшгийн үеийн тээвэрлэлт;
- 7) ачаалсан нийт жин нь 2.5 тонноос ихгүй ачих тээврийн хэрэгслийг ашиглах тээвэрлэлт;
- 8) шинээр худалдан авсан тээврийн хэрэгслийн ачаагүй анхны аялал.

2. Дараах төрлийн аялалд зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлнө.

- 1) Хэлэлцэн тохиролцогч аль ч улсын нутаг дэвсгэрт эвдэрсэн тээврийн хэрэгслийг солихоор, мөн тухайн тээврийн хэрэгслээс ачааг авахаар явуулсан ачаа тээврийн хэрэгслийн ачаагүй үеийн аялал;
- 2) засвар үйлчилгээний тусламжийн тээврийн хэрэгслийн аялал.

3. Энэхүү хэлэлцээрийн 12 дугаар зүйлд заасан Хамтарсан хороо нь зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тухай энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан тээвэрлэлтийн төрлүүд ба 2 дахь хэсэгт заасан аяллын төрлөөс бусад тээврийн төрлийг зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх талаар санал гаргаж болно.

7 дугаар зүйл Жин ба хэмжээ

1. Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн бүрэн ачаалсан жин, тэнхлэгийн ачаалал эсхүл овор хэмжээ нь мөрдөгдөж буй хязгаараас хэтэрсэн бол тухайн Хэлэлцэн тохиролцогч талын тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу урьдчилан хүсэлт гаргаж, тусгай зөвшөөрлийг авна.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөл нь тээврийн хэрэгслийн аяллыг тодорхой замналаар хийхээр хязгаарлах эсхүл бусад хязгаарлалт, шаардлагыг тавьж болно.

8 дугаар зүйл Аюултай болон түргэн гэмтэх, муудах ачааны тээвэрлэлт

Аюултай болон түргэн гэмтэх, муудах ачааны тээвэрлэлтийг тухайн улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэхдээ Хэлэлцэн тохиролцогч талын тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

9 дүгээр зүйл Нийтлэг нөхцөлүүд

Энэхүү хэлэлцээрийн болон Хэлэлцэн тохиролцогч талуудын тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн хүрээнд шаардагдах зөвшөөрөл болон бусад бичиг баримтыг тээврийн хэрэгсэлд дотор авч явах ба хяналтын байгууллагын шаардлагаар шалгуулна.

10 дугаар зүйл Даатгал

1. Тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын улсын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ эрх бүхий байгууллагын шаардсаны дагуу бусдад учруулсан хохирлын нөхөн төлбөрийг барагдуулах гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал хүчинтэй болохыг гэрчлэх бичиг баримтыг шалгуулна.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бичиг баримтыг тээврийн хэрэгсэл, эсхүл автобусанд авч яваагүй бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ тээвэрлэгч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гуравдагч талын хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

11 дүгээр зүйл Татвар ба хураамж

1. Энэхүү хэлэлцээрт заасны дагуу гүйцэтгэж буй зорчигч ба ачаа тээвэрлэлтэд Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гаалийн татвар, албан татвар ба бусад төлбөр хураамжийг ногдуулна.

2. Тээврийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай сэлбэг, эд анги ба нөөц, тухайлбал, үйлдвэрлэгчээс тээврийн хэрэгсэлд суурилуулсан түлшний стандарт саванд агуулагдаж байгаа шатахуун тос, тослох материалыг тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу хүлээн авагч Хэлэлцэн тохиролцогч талын улсын нутаг дэвсгэр дээр импортын татвар, татвар болон бусад төлбөр хураамжаас чөлөөлнө.

3. Хэлэлцэн тохиролцогч нэг талын улсын нутаг дэвсгэрт эвдэрсэн тээврийн хэрэгслийг засварлахаар түр хугацаанд импортолж буй сэлбэг, эд ангийг хэрэв хүлээн авагч Хэлэлцэн тохиролцогч талын дотоодын хууль тогтоомжид ийнхүү чөлөөлөх заалттай бол импортын бүх татвар болон бусад төлбөрөөс чөлөөлнө. Ашиглагдаагүй болон сольсон сэлбэг эд ангийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрээс буцааж гаргах, устгах эсхүл тухайн хүлээн авагч Хэлэлцэн тохиролцогч талын дотоодын хууль тогтоомжийн дагуу хүлээлгэн өгнө.

12 дугаар зүйл Хамтарсан хороо

1. Хэлэлцэн тохиролцогч талуудын улсын эрх бүхий байгууллагууд энэхүү хэлэлцээрийн нөхцөлийн хэрэгжилтийг хангах болон гарч болзошгүй аливаа маргааныг шийдвэрлэх зорилгоор Хамтарсан хороог байгуулна.

2. Хамтарсан хороо нь шаардлагатай бол Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн нутаг дэвсгэрт ээлжлэн хуралдана.

13 дугаар зүйл Тээвэрлэгчийн үүрэг хариуцлага ба зөрчил

1. Хэлэлцэн тохиролцогч нэг талын тээвэрлэгч болон түүний багийн гишүүд нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байх үед Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын тухайн улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дотоодын хууль тогтоомжийг, ялангуяа замын хөдөлгөөний тухай болон тээвэр зохицуулалтын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын улсын нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохиролцогч нэг талын тээвэрлэгч энэхүү хэлэлцээрийн нөхцөлийг зөрчсөн тохиолдолд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллагууд тээврийн хэрэгсэл нь бүртгэлтэй Хэлэлцэн тохиролцогч талын улсын эрх бүхий байгууллагад энэ тухай мэдэгдэнэ.

3. Нутаг дэвсгэрт нь зөрчил гарсан Хэлэлцэн тохиролцогч талын улсын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын тухайн улсын эрх бүхий байгууллагуудад дараах хүсэлтийг гаргаж болно:

- 1) Зөрчил гаргасан тээвэрлэгчид анхааруулга өгөх;
- 2) Нутаг дэвсгэрт нь зөрчил гарсан Хэлэлцэн тохиролцогч талд автотээвэрлэлт гүйцэтгэх тээвэрлэгчийн эрхийг түр хугацаагаар, хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түдгэлзүүлэх.

4. Хэлэлцэн тохиролцогч талуудын тухайн улсын эрх бүхий байгууллагууд нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар харилцан мэдээлнэ.

14 дүгээр зүйл **Эрх бүхий байгууллагууд**

1. Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах эрх бүхий байгууллагууд нь:

- Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж: Автотээврээр гүйцэтгэх зорчигч болон ачаа тээвэрлэлтийн асуудал хариуцсан яам (сайд).
- Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрыг төлөөлж: Автотээврээр гүйцэтгэх зорчигч болон ачаа тээвэрлэлтийн асуудал хариуцсан сайд.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан эрх бүхий байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд тухайн мэдээллийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

15 дугаар зүйл **Төгсгөлийн заалт**

1. Энэхүү хэлэлцээрээр эсхүл тал тус бүрийн нэгдэн орсон олон улсын хэлэлцээрээр зохицуулаагүй аливаа нэг асуудлыг тал тус бүрийн улсын дотоодын хууль тогтоомжоор зохицуулна.

2. Хэлэлцэн тохиролцогч талуудын харилцан зөвшилцсөнөөр энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тусдаа протокол байгуулах хэлбэрээр үйлдэнэ. Уг протокол нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болно. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн 16 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болно.

3. Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү хэлэлцээрийн хүрээнд аюулгүй байдал болон утааны найрлагын стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслийг ашиглахыг дэмжинэ.

16 дүгээр зүйл **Хэлэлцээр хүчин төгөлдөр болох ба үргэлжлэх хугацаа**

1. Энэхүү хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагаа хангасан талаар Хэлэлцэн тохиролцогч

талууд дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээрийг тодорхойгүй хугацаагаар байгуулав. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар мэдэгдэж, хэлэлцээрийг цуцалж болно. Энэ тохиолдолд хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш зургаан сарын дараа хүчингүй болно.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ, тус тусын Засгийн газраас бүрэн эрх олгогдсон эрх бүхий албан тушаалтнууд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажуулав.

Энэхүү хэлэлцээрийг 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, польш, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр адил хүчинтэй байна. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:



БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

